

## СЭТГҮҮЛЧИЙН ЁС ЗҮЙН “ҮНЭНИЙГ ЭРЭЛХИЙЛЖ, ҮНЭНИЙГ МЭДЭЭЛНЭ” ҮНДСЭН ЗАРЧМЫГ ТАЙЛБАРЛАХ НЬ

Д.Идэржаргал\*

\*МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн багш, магистр (МА)

**Түлхүүр үгс:** сэтгүүлчийн ёс зүй, ёс зүйн үндсэн зарчмууд, үнэн бодит мэдээлэл, нягт нямбай байдал, шударга байдал.

Олон улсад сэтгүүлчийн ёс зүйн асуудалд анхаардаг мэргэжлийн холбоод сэтгүүлчийн ёс зүйн зарчмын агуулгыг салбарын хөгжлийн дагуу нэмж баяжуулж байдаг. Тэдгээр олон кодоод ([accountablejournalism.org](http://accountablejournalism.org)) үргэлж давхцаж байдаг сэтгүүлчийн ёс зүйн үндсэн зургаан зарчим бий. Эдгээр нь:

1. Үнэнийг эрэлхийлж үнэнийг мэдээлнэ
2. Хор уршгийг бууруулна
3. Заль мэх, төөрөгдүүлэлт, худал ташаа арга ашиглахгүй
4. Ашиг сонирхлын зөрчилгүй ажиллана
5. Хүнлэг байна
6. Ялгаат байдлыг хүлээн зөвшөөрнө (сүүлд нэмэгдсэн) болно.

Энэ удаа сэтгүүлчийн ёс зүйн үндсэн зарчмуудаас “Үнэнийг эрэлхийлж, үнэнийг мэдээлнэ” зарчмыг авч үзье. Үнэнийг мэдээлэх зарчим

бол сэтгүүл зүйн зүрх юм. Хэрвээ олон нийтийн мэдээллийн хэрэгслээр цацагдаж буй мэдээлэл үнэн бодитой биш бол ямар ч ач холбогдолгүй. Тийм ч учраас үнэн бодитой байх нь сэтгүүл зүйн ёс зүйгээс гадна үйл ажиллагааных нь үндсэн зарчмуудын нэгдүгээрт бичигддэг.

Сэтгүүл зүйн “зорилго-үүрэг-зарчим” хэмээх хэлхээ холбоонд орших гурван ойлголтын аль нэг нь өөрчлөгдөхөд үлдсэн нь даган өөрчлөгдөх учир үүрэг, зорилгыг даган олон нийтийн мэдээллийн хэрэгслийн зарчим өөрчлөгдөх нь мэдээж юм (М.Зулькафиль, 2016). Хэдийгээр сэтгүүл зүйн түүхэнд зорилго, үүргээсээ хамаарч зарчим нь өөрчлөгдөж ирсэн нь үнэн ч өнөөгийн ардчилсан үзэл санаа, олон ургалч байдлын төлөөх сэтгүүл зүйн үнэн бодитой байдлыг өгүүлэх зарчим хэзээ ч өөрчлөгдөх ёсгүй билээ. Сэтгүүл зүйн үнэн бодитой байх зарчмын ач холбогдлыг судлаач М.Зулькафиль “Сэтгүүл зүйн хувь заяа түүний мэдээллийн үнэн бодит байх эсэхээс шууд шалт-

гаалдаг” хэмээн дүгнэсэн байдаг. Тэр бээр тус зарчмыг тайлбарлахдаа “Ер нь сэтгүүл зүйн эцсийн зорилго ч олон түмнийг үнэн бодитой мэдээллээр хангахад оршдог. Сэтгүүл зүй бодит байдлын тусгал байдгаараа бусад нийгмийн институтээс эрс ялгаатай. Бодит байдлын аливаа нэг хэсгийн мөн чанарыг тодорхой бөгөөд бүрэн харуулахын тулд амьдралаар шалгагдсан бодит баримтад түшиглэх нь зарчмын чухал ач холбогдолтой юм. Тохиолдлын чанартай, урсгал шинжтэй, амьдралаас тасархай баримтад биш, үнэн баримтыг мэдээллийн эх суурт болгох нь сэтгүүл зүйн үйл ажиллагааны амжилтын үндэс болдог” (М.Зулькафиль, 2016) гэжээ.

**С**этгүүл зүйн үйл ажиллагааны амжилтын үндэс болсон үнэн бодит байдлыг хангахад “Үнэнийг эрэлхийлж, үнэнийг мэдээлнэ” ёс зүйн зарчим чухал үүрэг гүйцэтгэдэг. Учир нь тус зарчим зөвхөн үнэн бодит байдлыг мэдээлнэ гээд орхидоггүй, хэрхэн ингэж мэдээлэх тухай нарийн тодорхой, практик зөвлөмж болдгийг олон улсын нэр хүндтэй хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн ёс зүйн кодуудаас харж болно. Тэдгээр кодуудад “Үнэнийг эрэлхийлж, үнэнийг мэдээлэх” ёс зүйн зарчим нь нягт нямбай болон шударга ажиллах гэсэн хоёр үндсэн ойлголтоос бүрддэг гэж үздэг. Өөрөөр хэлбэл үнэнийг мэдээлэх зарчим нь сэтгүүлч нягт нямбай, шударга ажилласнаар хүлээн авагчдыг үнэ цэнтэй, үнэн зөв, тэнцвэртэй мэдээллээр хангах үүрэгтэй нь

холбож өгдөг. Одоо энэ хоёр ойлголтыг тус бүрчлэн авч үзье.


Нягт нямбай байх гэдэг нь үнэн эсэхийг баталгаажуулахтай утга дүйнэ. Энэ бол сэтгүүлч хүн болон хэвлэл мэдээллийн байгууллагын амин чухал үүрэг юм. Мэргэжлийн сэтгүүлчид худал мэдээлэл түгээх юм бол олон нийтийг төөрөгдүүлэх зэргээр зогсохгүй тэдний сэтгүүл зүйд итгэх итгэлийг бууруулах аюултай. Уншигчид танай сониныг захиалж, телевизийг үзэж, сайтаар зочлохдоо амьдарч буй нийгмийнхээ тухай нэг талыг бариагүй, үнэн зөв мэдээллийг олж авах гэж хүлээдгийг мартаж болохгүй. Тиймээс нягт нямбай ажиллахын үндэс нь мэдээ мэдээлэл үнэн зөв болохыг нотлохын тулд баримтуудыг баталгаажуулах бүхий л арга хэмжээг авахаас эхэлдэг. Материал нийтлэх хугацаа тулсан, түрүүлж нийтлэхээр өрсөлдсөн, төхөөрөмж хэрэгсэл ажиллаагүй, дутагдалтай байсан гэх мэт ямар ч шалтгаан үнэн бус хийгээд нэг талыг барьсан мэдээллийг зөвтгөхгүй.

Шударга ажиллах гэдэг нь үнэнийг идэвх зориг, энэрэнгүй сэтгэлээр эрэлхийлж, үйл явдлыг хувийн ашиг сонирхол болон алагчлалгүйгээр сурвалжлахыг хэлдэг. Шударга байдал нь асуудлыг мэдээлэхдээ нэг талыг барих, хэвшмэл ойлголтоор хандах, батлагдаагүй мэдээлэл түгээхгүй байхыг хэлж байна.

Үнэн бодитой байх зарчим нь тухайн хэвлэл мэдээлэл ба түүний хэрэглэгчдийн хоорондох итгэлц-

лийн хэмжүүр болдог. Бодитой мэдээлэлтэй мэдээллийн хэрэгсэлд хэрэглэгчид нь итгэснээр захиалгын болон зар өгөгчдийн тоо нэмэгдэж тухайн хэвлэл мэдээллийн байгууллага санхүүгийн хувьд ашиг олох төдийгүй нийгэмд эзлэх байр суурь нь дээшилж бэхэжнэ. Тиймээс агуулгын бодит байдлыг хэрхэн хангах схемийг судлаач Юрген Уэстертах 1983 онд Шведийн өргөн нэвтрүүлэгт хийсэн судалгаагаараа гаргажээ (Зураг 1). Түүний санал болгож буй схемд ч үнэн бодит

байдлыг хангахын тулд сэтгүүлчид нэгдүгээрт баримтаар нотлох, хоёрдугаар асуудалд шударга хандах ёстойг тодорхойлжээ. Баримтаар нотлохдоо үнэнийг нотлох баримтуудыг сонгож, учир холбогдлыг нь гаргаж өгвөл мэдээллийн агууламж нэмэгдэнэ. Харин шударга ажиллахын тулд тэнцвэртэй мэдээлж, төвийг сахих ёстойг онцолсон нь олон улсын ёс зүйн кодуудын үнэнийг мэдээлэх заавартай дүйж байгаа хэрэг.



Зураг 1. Юрген Уэстертахын үнэн бодит байдлыг хангах схем.

“Үнэнийг эрэлхийлж, үнэнийг мэдээлнэ” ёс зүйн зарчмын талаарх олон улсын сонгодог кэйсүүдэд нягт нямбай ба шударга байдлыг хэрхэн хангасныг авч үзье. Эхнийх нь “Конгрессын гишүүний өнгөрсөн амьдрал”. 2004 оны сонгуулиас гуравхан долоо хоногийн өмнө “The Oregonian” (Portland) сонин сенсацийтай нийтлэл гаргав. Тус нийтлэлд Ардчилсан намаас дөрөв дэх удаагаа Конгресст суухаар нэр дэвшиж буй Дэвид Вуг 28 жилийн өмнө экс найз бүсгүйгээ бэлгийн дарамтад оруулсан тухай өгүүлжээ. Гэвч энэ хэргийн талаар гэмт хэргийн бүртгэл хийгдээгүй бөгөөд

Ву, эмэгтэй хоёрын хэн нь ч хэргийг одоо шийдэхийг хүсээгүй байна. “The Oregonian” сониныхон цуу яриа үнэн эсэхийг олж мэдэхийн тулд олон сарын хугацааг зарцуулжээ. 2004 оны аравдугаар сарын 12-нд сонин 3000 гаруй үгтэй нийтлэл гаргахдаа хэргийн талаар юу олж мэдсэнээ тайлбарласан байна. Нийтлэл хэвлэгдсэн өдөр ноён Ву хэвлэлийн бага хурал хийж залуудаа гаргасан алдаандаа харамсаж буйгаа илэрхийлээд, энэ хэрэг одоо чухал биш гэж бодож буйгаа мэдэгджээ. Мэдээж бусад ХМХ-үүд энэ талаар мэдээлж, Бүгд найрамдах намаас нэр дэвшигчид ч

кампанит ажилдаа шүүрэн авч ашиглав.

Олон жилийн өмнөх хэргийн талаар товч дурдвал, Дэвид Ву болон түүний экс найз бүсгүй Стэнфордын Их Сургуульд хамт сурдаг байсан бөгөөд 1976 оны хавар салсан байна. Тэр зун найз бүсгүй асан нь Вуг өөртэй нь бэлгийн харилцаанд орохыг хүчлэхийг оролдсон гэж мэдэгдсэний дараа Вуг Стэнфордын кампусын цагдаа байцаасан байна. Ву цагдаад тэр явдлыг харилцан зөвшилцөл байсан гэж мэдэгдсэн бөгөөд баривчлагдаагүй аж. Эмэгтэй ч зарга үүсгэх өргөдөл гаргахаас татгалзжээ. “The Oregonian” сонин 28 жилийн дараа хэргийн талаар асууж холбогдох Ву ярилцлага өгөх, асуултад хариулахаас татгалзжээ. Вугийн экс найз бүсгүй ч мөн ийм хариу өгч. Стэнфордын албаныхан их сургуулийн бодлого, оюутны нууцлалын журмын дагуу мэдээж ийм хэргийг авч хэлэлцэхгүй.

Тэгвэл “The Oregonian” хаанаас мэдээлэл олов? Сонины нийтлэлд “Сэтгүүлчид юу болсныг тодорхойлохоор Стэнфордын тухайн үеийн оюутнууд, их сургуулийн өнөөгийн болон тэтгэвэрт гарсан албан хаагчид, профессорууд, хуулийн мэргэжилтнүүд, Вугийн найзууд болон өмнөх сонгуулиудын кампанит ажлын багийнхан зэрэг олон арван хүнтэй уулзсан... Дараах нийтлэл нь тухайн үед Стэнфордын оюутны байрны хянагчаар ажиллаж байсан хүмүүс болон кампуст

байсан оюутнуудын ярианд үндэслэсэн” гэжээ.

Сонин ийм зүйл нийтэлснээрээ нэр хүндээ дэнчинд тавьсан юм. Учир нь Сонгуульд Вутай өрсөлдөгчид энэ нийтлэлийг ашиглахыг хүсэх нь ойлгомжтой. Олон нийт сар хүрэхгүй хугацааны дараа Конгресст дүүргээ төлөөлөх хүнийг сонгоно. Мэдээж сэтгүүлчийн ёс зүйд үнэнийг өгүүлэх ёстой гэдэг ч тэрхүү “үнэн” сонгуулийн үр дүнг өөрчилж болох тийм нөхцөлд энэ мэдээлэл цацагдсан байна.

**Д**уулиан тарьсан нийтлэл хэвлэгдсэний дараа нэр дэвшигч Дэвид Ву хэвлэлийн бага хурал зарлаж өөрийн байр сууриа илэрхийлэхдээ нэгдүгээрт, тийм зүйл (экс найз бүсгүйгээ бэлгийн харилцаанд орохыг хүчилсэн) болоогүй; хоёрдугаарт 30 орчим жилийн өмнө болсон тодорхойгүй хэрэг одоо тийм чухал гэж үү? гэж асуужээ. Тус сонины 2004 оны 10 сарын 17-ны өдрийн дугаарт редактор Майкл Арриэта-Валден олон нийтээс уучлал хүссэн байдаг.

“The Oregonian” сонины энэхүү кэйс нь үнэн бодит байдлыг хангахын тулд асар их хүч хөдөлмөр зарцуулсан ч үр дүнд “хүрээгүй” явдалд тооцогддог. Учир нь сонины баг үйл явдлын үнэн бодитойг баталгаажуулж чадаагүй гэж мэргэжлийн ёс зүй судлаачид үзсэн юм. Өөрөөр хэлбэл, 30 жилийн өмнөх үйл явдлыг нотлох гэж оролдохдоо анхдагч эх сурвалжууд мэдээлэл өгөхөөс татгалзсан учраас дам эх сурвалжуудыг ашиглаж, тэдний өгсөн итгэл муутай

эшлэлүүдийг баримт болгон ашигласан байна.

Сэтгүүл зүйн практик үнэн бодитой байдлыг зөрчих тохиолдол цөөнгүй гарч гардаг нь эх сурвалжтай холбоотой болохыг судлаач М.Зулькафиль тэмдэглэсэнтэй (М.Зулькафиль, 2016) дээрх кэйс тохирч байна. Тодруулбал, “Өнөөдөр сонин хэвлэлийн нийтлэлд, радио телевизийн нэвтрүүлэгт бүрэн гүйцэт шалгаагүй баримт сэлт, мэдээ мэдээлэл, сонгож авсан баримтыг сайн дураараа андуурах, буруу зөрүү тайлбар хийх явдал түгээмэл байгаа бөгөөд үүний гол шалтгаан нь эх сурвалж хангалтгүй, түүнд хийх дүн шинжилгээ дутмаг байх, эх сурвалжаас үнэн бодитой мэдээлэл олж авахад саад бэрхшээл байгаатай холбоотой юм” гэжээ.

**Б**идний танилцуулах дараагийн кэйс нь АНУ-ын түүхэндэх шоронгийн хамгийн том бослоготой холбогдож, шаардлагатай тохиолдолд үнэнийг өгүүлэхээс татгалзах ёс зүй сэтгүүл зүйд байх ёстойг харуулна.

2005 оны нэгдүгээр сарын 18-нд Аризонагийн шоронгийн цогцолборт хоёр хоригдол гараар хийсэн зэвсгээр зэвсэглэж, шоронгийн хамгаалалтын цамхгийг хяналтдаа авчжээ. Тэд засан хүмүүжүүлэх хоёр офицерыг барьцаалснаас эрэгтэйг нь суллаж, эмэгтэйг нь бууж өгөхийнхөө өмнө буюу хоёр долоо хоногийн дараа (хоёрдугаар сарын нэгэнд) суллажээ. Гэвч олон нийт хэрэг явдлыг дуусах хүртэл юу ч мэдээгүй. Тухайн үе хэвлэл мэдээл-

лийн хэрэгслүүдийг шоронд 500 метрээс дотогшоо ойртохыг хориглосон бөгөөд нисдэг тэрэг нисэхийг ч хязгаарлажээ. Эрх барих байгууллагын төлөөлөл энэ явдлыг тайлбарлахдаа шоронгийн хоёр хамгаалагчийн аюулгүй байдлыг харгалзсан үзсэн бөгөөд муж улсын бүхий л ОНМХ-ийн эрхлэгчидтэй холбогдож тодорхой үндсэн мэдээллийг цацахгүй байхыг ятгасан байна. Бослого үргэлжлэх үеэр ОНМХ-ийн мэдээлэл хоригдлуудад хүрч тэдэнтэй хийх тохироог нурааж магадгүй гэж үзжээ. Телевиз, радио, сонин сайт бослого дуусах хүртэл хүлээн авагчдадаа барьцаалагдсан хүмүүсийн нэрийг огт задлаагүй бөгөөд барьцаалагчдын гэмт хэргийн түүх, мэдээллийг ч мөн нууцалжээ. Төрийн албаныхан хэрэгт холбогдсон хүмүүсийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөх болон бослого хэрхэн эхэлсэн, бослогын улмаас ямар хор хохирол учирсныг мэдээлэхээс татгалзсан байна.

Сэтгүүлчийн үүрэг бол үнэнийг хэлэх бас хор хохирлыг бууруулах. Энэ тохиолдолд сэтгүүлчийн ёс зүйтэй холбоотой олон асуулт гарч ирнэ. Аризонагийн хэвлэлүүд зөв шийдвэр гаргасан уу? Хэрхэн ажиллах ёстой байсан бэ? Та тэдний оронд байсан бол эрх баригчидтай хамтран ажиллах байсан уу? Хамтын ажиллагаандаа ямар нэгэн болзол тавих байсан уу? Өрсөлдөөнд санаа зовох байсан уу? Мэдээллийг цацахаа хэр удаан хугацаанд азнах байсан бэ? Нэгдсэн байр суурь үүсгэхийн тулд өөр хэвлэлүүдтэй хамтран ажиллах

байсан уу? Өөр мужийн хэвлэлүүд тодорхой мэдээллийг дэлгэж эхэлсэн бол танай хэвлэл мэдээллийг нууцалсан хэвээр л байх уу? гэх мэт олон асуулт урган гарна.

Гэвч энэ тохиолдолд Аризонагийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд хохирогчдыг бодсон зөв шийдвэр гаргажээ. Хоригдлууд хүн зодсон, барьцаалсан, бэлгийн хүчирхийлэл үйлдсэн зэрэг хэргээр ял эдэлж байсан гэдгээс та бослогын үеэр юу болсон байх магадлалтайг, яагаад эрэгтэй хамгаалагчийг суллаад эмэгтэйг нь авч үлдсэнийг таамаглаж болно. Аризонагийн хэвлэлүүд өөр эх сурвалжаас олж авч болох хэрэгт холбогдогчдын нэр зэргийг мэдээлэхгүй байхаар шийдэж, барьцаалагчид гэж сэжиглэж байсан хоригдлуудын ар гэрийнхэнтэй уулзаж ярилцсанаа хүртэл нийтлэхээс татгалзжээ.

**С**этгүүлч мэргэжлийн ёс зүйд үнэнийг өгүүлэх ёстойг хэлдэг ч гэм хоргүй хэн нэгний амьдралд насан туршийн тамга болж хор хохирол учруулах тохиолдолд тэд үнэнийг өгүүлэхээс татгалзсан юм. Энэ хэргээс сэтгүүлчийн ёс зүйн зарчмууд бие биетэй харилцан хамааралтай байгааг харж болно.

Үнэнийг эрэлхийлж, үнэнийг мэдээлэх асуудал нь зөвхөн тухайн хэвлэл мэдээллийн хэрэгслийн нэр хүндээс гадна сэтгүүл зүйд итгэх итгэлд шууд нөлөөлж байдаг. Тиймээс сэтгүүлчид үнэн зөв мэдээлэл түгээж буй эсэхээ нягтлахдаа дараах хяналтын асуултуу-

дыг асууж, шалгаж дадах нь чухал юм. Залуу сэтгүүлчид энэ аргыг зуршил болгон хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

*Үнэн зөвийг нягтлах хяналтын асуултууд:*

- Та мэдээ, нийтлэлд тань орсон баримтууд хийгээд тэдгээрийн эх сурвалжид итгэж байна уу? Энэ асуултад итгэлтэйгээр тийм гэж хариулаагүй бол дараах хяналтын жагсаалтыг гүйцэтгэнэ үү.
- Та бүх баримтыг баримтжуулж хадгалсан уу?
- Та бүх баримтыг хоёр өөр эх сурвалжаар баталгаажуулсан уу?
- Та мэдээлэл авсан эх сурвалжийн овог нэр, утасны дугаарыг хадгалж үлдсэн үү?
- Таны нийтлэлд орсон баримттай мэдээлэл бүр үнэнийг илэрхийлж чадна гэдэгт итгэлтэй байна уу?
- Та баримтыг нягталсан арга олон нийтэд зарлахад бэлэн үү?
- Таны ашигласан эшлэл болон тэдгээрийн утгыг шударгаар гаргасан уу?
- Та нэргүй эх сурвалжаас эш татсан уу? Яагаад тэдгээр эх сурвалжийг ашигласан бэ? Тэдгээр эх сурвалжийг ашигласан шалтгаанаа олон нийтэд зөвтгөж чадах уу?
- Та нэргүй эх сурвалжаас ямар нэг баримт, зураг авч ашигласан уу? Яагаад? Энэ материалын үнэ цэний талаарх таны итгэл үнэмшил хэр байна вэ? Тэдгээр материалыг ашигласан шалтгаанаа олон нийтэд зөвтгөж чадах уу?

- Та хүмүүс, үндэстний цөөнх, үндэстэн, соёл эсвэл нийгмийн сегментийг дүрслэхдээ хэвшмэл ойлголтоор хандсан уу? Тэдгээр дүрслэл үнэн зөв хийгээд утга учиртай байна уу?
- Та нийтлэлдээ зохимжгүй үг хэллэг эсвэл зураг ашигласан уу? Ийм мэдээлэл ашиглахыг зөвтгөх шалтган байна уу? Хэрвээ тэр үг хэллэг, зургийг хасчихвал нийтлэл үнэн зөв биш болох уу?
- Таны өгсөн гарчиг нийтлэлийн баримт, агуулгатай тохирч байна уу?

**Х**арин одоо олон улсын нэр хүндтэй хэвлэлүүдийн ёс зүйн кодуудад нягт нямбай, шударга ажиллахыг хэрхэн тусгасныг түүвэрлэн хүргэе.

*Детройтын чөлөөт хэвлэл.* Бид үнэнийг мэдээлэхдээ шударга аргаар ажиллана гэж дараах амлалтыг өгч байна:

- Бид мэдээ болон түүний хам сэдвийг ч нягт нямбай сурвалжилна.
- Бид мэдээлэл цуглуулах, сурвалжлах, үзүүлэхдээ шударга аргаар ажиллана.
- Бид түүхийг бүхэлд нь сурвалжлахын тулд шургуу ажиллана.
- Үзэл бодлын тойм (opinion column), редакцын зурваст ч мэдээний адил баримттай нягт нямбай ажиллах стандартыг баримтална.

*San Jose Mercury News.*

- Худал хуурмагийг мэдсэн атлаа нийтлэхийг хэзээ ч зөвтгөхгүй.
- Сэтгүүлч гуравдагч тал болон мэдээлэл хүлээн авахгүй. Оролцоогүй үйл явдлынхаа талаах бичихгүй. Жишээ нь, эх сурвалж нэгэн танил сэтгүүлчид мэдээлэл өгснийг түүнээс авч хэвлэн нийтлэхгүй.
- Зурагчид, редакторууд фото зургийг зохиомжилж байгаа тохиолдолд заавал харилцан сануулна. Сэтгүүлчид эшлэлийг эвлүүлж зохиохгүй бөгөөд зурагчид яг тийм байсан мэт харагдуулах зорилгоор баримтат зургийн эд зүйлсийг өөрчилж, хөдөлгөж, солихгүй.
- Гэрэл зургийг зохиомжилж авсан тохиолдолд тайлбарт заавал тодорхой өгүүлнэ. Тухайлбал, Жүдогийн тамирчин А үндсэн мэхээ давтаж байна эсвэл Жүдогийн тамирчин А үндсэн мэхээ давтаж үзүүлэв зэрэг нь ялгаатай.

*Денвер Пост.*

- Бидний зорилго бол баримтыг таамаглал, хам сэдэвтэй хамт хүргэх.
- Бид хоёр талаас биш бүх талаас мэдээлэл авна.
- Сайн мэдээ, нийтлэл олон эх сурвалжтай байдаг.
- Баримтуудыг гурван эх сурвалжаар баталгаажуулна.
- Асуудлыг олон талаас, олон эх сурвалжийн байр сууриар харахыг хичээнэ.

*Нью-Йорк Таймс.*

- Мэдээ, нийтлэлийн аль ч хэсэгт мэдсэн атлаа худал хуурмаг мэдээлэл нийтэлсэн бол хүлцэн тэвчихгүй бөгөөд ажлаас халах хүртэлх арга хэмжээ авна. (Жэйсон Блэйрийн цувралаас 3 жилийн өмнө буюу 2000 оны 12 дугаар сараас)

*Вашингтон Пост.*

- Энэ сонин ёс зүйн алдаа гаргахгүйг, гаргасан бол тоог нь бууруулах болон алдаагаа тухай бүрд нь залруулахыг эрмэлзэнэ.
- Нягт нямбай байдал бол бидний зорилго. Шударга байдал бол бидний бамбай.
- Ёс зүйн алдаа гаргасан сэтгүүлчийг сайтар сонсож нөхцөл байдлыг дүгнэнэ.

*Виржиниан Пайлот.* Хүүрнэл зохиол бичихэд алдаа гаргахаас сэргийлэх аргууд:

- Олон өдөрт болсон үйл явдлыг ганц өдөрт болсон мэтээр дүрслэхгүй.
- Биеэр оролцож, үзэж хараагүй болон тодорхой мэдлэггүй үйл явдлынхаа талаар нарийн тодорхой дүрслэхгүй.
- Эх сурвалж өөрөө хэлээгүй тохиолдолд түүний юу мэдэрч, бодож буйг өөрийн мэдрэмждээ үндэслэн бичих.

*Хёрстийн сонинууд.*

- Манай сонинд санаатайгаар хуурамч мэдээлэл түгээхийг тэвчихгүй. Худал хуурмагийг нийтэлсэн алдаа нь заримдаа үндэслэлтэй байдаг, тэр тохиолдолд сонин алдааг аль

болох хурдан, цогц байдлаар залруулах үүрэгтэй. Дотоод журмаар хариуцлага тооцох бол редактор хариуцлага хүлээнэ.

*Ассошиэтэд Прессийн Хяналтын редакторууд.*

- Сонин технологийн төөрөгдүүлэлт болон хайхрамжгүй байдлаас үүдэн гарах нягт нямбай бус байдал, нэг талыг барьсан эсвэл худал хуурмаг мэдээллийн эсрэг сэрэмжтэй байна.
- Алдаа гаргасан тохиолдолд алдаагаа хүлээн зөвшөөрч, аль болох хурдан, цогц байдлаар залруулна.

*Америкийн мэдээний редакторуудын нийгэмлэг.*

- Үнэн ба нягт нямбай байдал. Хүлээн авагчдын итгэлийг хүлээнэ гэдэг сайн сэтгүүл зүйн үндэс. Мэдээний агуулгыг үнэн зөв, тэнцвэртэй байлгахыг үргэлж эрмэлзэнэ. Редакцын зурвас, дүн шинжилгээ бүхий нийтлэл, үзэл бодлыг тайлбарт ч мэдээний адил баримттай нягт нямбай ажиллах стандартыг баримтална. Хайнга байдал зэргээс үүдсэн баримтын алдааг аль болох хурдан, цогц байдлаар залруулна.

**Эшлэл:**

1. <https://accountablejournalism.org/ethics-codes/international>
2. М.Зулькафиль. Сэтгүүл зүйн судалгааны бүтээлүүд. II боть. Сэтгүүл зүйн онолын үндэс. 2016. Ху 110.



3. М.Зулькафиль. Сэтгүүл зүйн судалгааны бүтээлүүд. II боть. Сэтгүүл зүйн онолын үндэс. 2016. Ху 111.
4. М.Зулькафиль. Сэтгүүл зүйн судалгааны бүтээлүүд. II боть. Сэтгүүл зүйн онолын үндэс. 2016. Ху 114.

**Ашигласан бүтээлийн жагсаалт:**

1. М.Зулькафиль. Сэтгүүл зүйн судалгааны бүтээлүүд: Боть-10: Сэтгүүлчийн хөдөлмөр: Ёс зүй, хариуцлага, үнэлэмж. УБ. 2017.
2. М.Зулькафиль. Сэтгүүл зүйн судалгааны бүтээлүүд. II боть. Сэтгүүл зүйн онолын үндэс. УБ. 2016.
3. Ч. Чойсамба. Сэтгүүлчийн ёс зүйн алдаа. УБ. 2014.
4. Д.Тунгалаг. Мэргэжлийн ба хэрэглээний ёс зүй. УБ. 2007.

5. Ч. Чойсамба. Ёс зүйн тухай өгүүллэгүүд. УБ. 2016.
6. [www.accountablejournalism.org](http://www.accountablejournalism.org)
7. [www.poynter.org](http://www.poynter.org)

**Summary**

In this article, the author aims to explain in theory and practice the principle of seeking and reporting the truth, which is the basic principle of journalism ethics. The author explained the concepts of accountability and honesty in order to report the truth. It also analyzes classic cases of ethics related to reporting truths. Finally, a sample of how the international press incorporated this principle into its code of ethics was presented, with review questions to verify its accuracy.